

БАТЛАВ.
ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



ТӨСВИЙН ЗАХИРАГЧДЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
ЗАВСРЫН ҮЕИЙН АУДИТ ХИЙХ УДИРДАМЖ

Төсвийн захирагчдын 2023 оны санхүүгийн тайлангийн завсрын үеийн аудитыг 2023 оны 8 дугаар сарын 31-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хооронд батлагдсан хуваарийн дагуу багаар гүйцэтгэнэ.

МУЕА-ын 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”-ын 3.12-д заасны дагуу завсрын аудитыг хийж гүйцэтгэх ба дараах асуудалд анхаарч ажиллана. Үүнд:

1. Тухайн жилд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитын батлагдсан жагсаалтын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын харьяа байгууллагуудыг тулган баталгаажуулж, шаардлагатай тохиолдолд аудитын менежерт мэдэгдэх
2. Түүвэрт хамрагдах байгууллагын санхүүгийн тайланд шинжилгээ хийж, эрсдэлтэй ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийг тодорхойлж, хэрэгжүүлэх горим, сорилыг гүйцэтгэж баримтжуулах
3. Завсрын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаарх шийдлийн асуудлын бүртгэл хөтөлж, үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэх
4. Санхүүгийн тайланд нь санал дүгнэлт гаргах шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд аудитын төлөвлөх үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг батлуулах
5. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар гүйцээн шалгах эрсдэл бүхий асуудал, арга зүйг тодорхойлон, аудитын төлөвлөгөөнд тусгах
6. Ахлах аудитор багийн завсрын аудитын календарьчилсан төлөвлөгөөг гаргаж, аудитын менежерээр хянуулах
7. Аудитын баг өмнө хийгдсэн аудитын тайлан, мэдээллийг судлах, байгууллагын талаарх ойлголтыг бүрэн авч, аудитыг гүйцэтгэх
8. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг нотлох баримтыг үндэслэн санхүүгийн тайлангийн аудитын Fas системээр хянаж, үнэлэх
9. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг төрийн аудитын байгууллагаас баталсан бодлого, чиглэл, хэрэгжүүлэх арга зүйн дагуу шалгах
10. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж, шалгах
11. Гэрээгээр аудит хийх аудитын хуулийн этгээдийн аудитын төлөвлөх үе шатны ажилбарууд, завсрын аудитын асуудлын бүртгэл, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтэд чанарын хяналт хэрэгжүүлэх
12. Санхүүгийн тайлангийн аудитын Fas системд аудитын урьдчилсан үйл ажиллагаа, төлөвлөлтийн үе шатны ажилбаруудыг гүйцэтгэх
13. Аудитын баг дараах хууль, стандарт, заавар, аргачлалыг уншиж танилцсан байна. Үүнд:
 - Төсвийн тухай хууль,
 - Төрийн аудитын тухай хууль,
 - Төрийн хэмнэлтийн тухай хууль,
 - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
 - Салбарын хууль, тогтоомжууд,
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,

- МУЕА-ын 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлал”,
 - Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах бодлого, чиглэл
 - МУЕА-ын 2020 оны А/93 дугаар тушаалаар баталсан “Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх журам”,
 - МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”,
 - МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”,
 - МУЕА-ын 2021 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Аудитын үр өгөөжийн журам”,
 - МУЕА-ын 2022 оны А/54 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам”,
 - МУЕА-ын 2022 оны А/101 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын статистик мэдээг боловсруулах, тайлагнах журам”,
 - МУЕА-ын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталсан “Аудитын чанарын хяналтын журам”,
 - МУЕА-ын 2023 оны А/27 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын мэдээлэл авах журам”,
 - АОУС
 - АДБОУС
14. Завсрын аудитаар гүйцэтгэж баримтжуулсан дээрх ажлууд нь тухайн байгууллагын жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулах ажилд чиглэх бөгөөд аудитын үе шатны чанарын хяналтыг хийлгэж, асуудлын бүртгэлийг баталгаажуулж, санхүүгийн тайлангийн аудитын Fas системд оруулсан байна.
15. Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар шалгагдагч байгууллагад зөвлөмж, албан шаардлага өгч, акт тогтоохдоо жилийн эцсийн санхүүгийн тайлангийн цаглабарт хугацаанаас өмнө хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдсэн эсэхийг харгалзан үзэх.